

ДААТГАЛЫН МЭДЭЭ

2009 ОНЫ 8 ДУГААР САР

1. САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ:

Даатгалын компаниудын даатгалын үйл ажиллагааны үндсэн үзүүлэлтүүдийг 2009 оны 8 дугаар сарын байдлаар харуулбал:


Ердийн даатгалын компаниудын хувьд : /төгрөгөөр/

	Үзүүлэлт	2009-VII	2009-VIII	Өөрчлөлт /хувиар/
1	Даатгалын нийт хураамж	1,853,989,738.05	2,148,035,373.27	15.9
2	Олгосон нийт нөхөн төлбөр	605,909,736.76	364,994,759.06	-39.8
3	Давхар даатгалд төлсөн хураамж	33,672,405.97	785,354,225.00	2232.3
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо /ширхэг/	7,779	4,689	-39.7
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	99,370,178,559.00	3,142,308,550.00	-96.8
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	101,790,080.00	45,000,000.00	-55.8

2009 оны 8 дугаар сарын даатгалын хураамжийн орлого 7 дугаар сарынхаас 15.9 хувиар нэмэгдсэн хэдий ч олгосон нөхөн төлбөр 39.8 хувиар буюу 241.0 сая төгрөгөөр буурсан байгаа нь 7 дугаар сард үер усны хохирлын нөхөн төлбөр ихээр олгож байсантай холбоотой байна.

8 дугаар сард даатгалын хураамжийн орлого 7 дугаар сарынхаас нэмэгдсэн хэдий ч даатгалын гэрээний тоо буурсан байгаа нь даатгалын компаниуд 8 дугаар сард даатгалын хураамж өндөртэй гэрээ байгуулсан болон өмнөх сарын даатгалын гэрээний орлого ихээр орж ирж байгаа нь нөлөөлж байна.

Даатгалын хураамжийн орлого болон нөхөн төлбөрийн харьцаа



Даатгалын компаниудаас 8 дугаар сард хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийг “Түшиг даатгал” ХХК нь хувь хүний тээврийн хэрэгслэлийн даатгалын гэрээгээр “Бэнз” машины нөхөн төлбөрт 45.0 сая төгрөг олгосон байна.

Урт хугацааны даатгалын компанийн хувьд :

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2009-VII	2009-VIII
1	Даатгалын нийт хураамж	476,246.00	3,566,247.00
2	Олгосон нийт нөхөн төлбөр	540,000.00	792,000.00
3	Давхар даатгалд төлсөн хураамж	-	3,816,265.50
4	Байгуулсан даатгалын гэрээний тоо	12 гэрээ	8 гэрээ
5	Даатгалын гэрээнүүдээс хамгийн өндөр үнэлгээний дүн	15,000,000.00	100,000,000.00
6	Хамгийн их дүнтэй нөхөн төлбөрийн дүн	540,000.00	540,000.00

“Нэйшнл лайф даатгал” ХХК-ийн даатгалын хураамжийн орлого 8 дугаар сард 7 дугаар сарынхаас 7.4 дахин буюу 3.1 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

8 дугаар сард “Нэйшнл лайф даатгал” ХХК 7 хувь хүнтэй “Хувь хүний хугацаат амьдралын даатгал”-ын гэрээ, “Ну тур” ХХК-тай “Байгууллагын хугацаат даатгал”-ын гэрээ байгуулсан байна. Гэнэтийн осол эмнэлгийн мөнгө нэмэлт нөхцөлөөр 792.0 мянган төгрөгийн нөхөн олговор олгосон байна.